



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 296

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цэвээнравдан овогтой Азбаяр, Далайхүү овогтой Ядамдорж, Бямбаа овогтой Баатарпүрэв, Д.Дамдинцэрэн нарыг ОХУ-ын Дотоод явдлын яамны Удирдлагын академид, Хөхөө овогтой Уламбаярыг ОХУ-ын Хууль зүйн яамны Эрх зүй, удирдлагын академид 2 жилийн хугацаагаар 2003-2004 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.

2. Эрдэнэбат овогтой Халиуныг Англи улсын Зүүн Лондоны Их сургуулийн харьяа Технологи, удирдлагын сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Цанжид овогтой Дэлгэрмааг Англи улсын Вестминстерийн Их сургуулийн магистрантурт олон улсын харилцаа, улс төрийн онолын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Чулуунжав овогтой Мөнхцэцэгийг АНУ-ын Лос Анжелес хотын Калифорнийн Их сургуулийн магистрантурт социологийн чиглэлээр, Цэрэнлхам овогтой Гантулгыг АНУ-ын Бриджпортын Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Баяр овогтой Батзундуйг АНУ-ын Колорадо Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Бямбаа овогтой Баатарсүхийг АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн Их сургуулийн магистрантурт эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлээр, Дорлиг овогтой Амарзаяаг АНУ-ын Акроны Их сургуулийн магистрантурт сэтгүүл зүйн чиглэлээр Гантөмөр овогтой Солонгыг Австрали улсын New South Wales Их сургуулийн магистрантурт тус бүр 2 жилийн хугацаагаар, Даваазана овогтой Оюунчимэгийг Данкүгийн Их сургуулийн докторантурт 3 жилийн хугацаагаар 2003-2004 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.

3. ХВНГУ-ын Берлин хотын Гумболдтын Их сургуулийн докторантурт элэг шилжүүлэн суулгах чиглэлээр суралцаж буй Гансүх овогтой Цэрэнчунт, ОХУ-ын Гадаад хэргийн яамны Дипломатын академид суралцаж буй Амгалан овогтой Ананд, Дэмчиг овогтой Тэгшжаргал нарын суралцах хугацааг 1 жилээр сунгасугай.

4. АНУ-ын Оклахома хотын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй Нямбаяр овогтой Тамирын төгсөх жилийн сургалтын зардал, АНУ-ын Де Врай Их сургуулийн Чикаго хот дахь Технологийн сургуульд компьютерийн инженер технологичийн мэргэжлээр суралцаж буй Уртнасан овогтой Сайнбаярын 2 жилийн сургалтын төлбөр, ОХУ-ын Москва хотын К.А.Тимирязевын нэрэмжит ХАА-н академийн докторантурт суралцаж буй Балдандорж овогтой Амаржаргалын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг тус тус зээлээр олгосугай.

5. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг, Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД,

А.ЦАНЖИД